



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Хөрөнгө оруулалт, худалдааны газар

Хөрөнгө оруулалтыг дэмжих хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Хөрөнгө оруулалтын дэмжлэг, арга хэмжээ хариуцсан мэргэжилтэн

Дэс түшмэл, ТЗ-7

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Засгийн газрын XI байр, Ж.Самбуугийн гудамж 11, Чингэлтэй дүүрэг Улаанбаатар хот, Монгол Улс, 15141

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хөрөнгө оруулалтын тухай хууль, холбогдох бусад хууль, журам, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг ханган, хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Хөрөнгө оруулалтын тухай хууль, холбогдох бусад хууль, журам, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг ханган, хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх, тайлагнах;
- 2.Монгол Улс дахь гадаад дотоодын хөрөнгө оруулалтын орчны талаарх мэдээлэл, хөрөнгө оруулалт эрэлхийлсэн салбарын тэргүүлэх төслүүдэд хөрөнгө оруулалт татах, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах, төслийн мэдээллийн сан үүсгэх, цахим хуудсаар сурталчлах, тайлагнах;
- 3.Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбогдох бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Хөрөнгө оруулалтын тухай хууль, холбогдох бусад хууль, журам, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг ханган, хөрөнгө оруулалтын бодлогод дэмжлэг үзүүлэх;	Хууль, тогтоомжийн хэрэгжилтийн үр дүн гарсан байна.	Т, Г
	2.Хөрөнгө оруулалт татах, сурталчлах, дэмжихтэй холбоотой цогц арга хэмжээний санал боловсруулах.	Хөрөнгө оруулалтыг үр дүнтэйгээр татан нутагшуулах санал боловсруулсан байна.	Т, Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Хөрөнгө оруулалт шаардлагатай, татан нутагшуулах боломжтой эдийн засгийн салбар, тэргүүлэх салбар, эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлүүдээр холбогдох судалгааг хийж, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох;	Холбогдох судалгааг хийж, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон байна.	Т, Г
	2.Хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны төлөвлөлт хийх, хөрөнгө оруулалтыг тогтвортой үргэлжлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	Дэмжлэг үзүүлэн ажилласан байна.	Т, Г
	3.Гадаадын хөрөнгө оруулагчдын хүсэлт, саналыг судалж, шийдвэрлэх, хөрөнгө оруулагчийн тодорхойлолт	Дэмжлэг үзүүлэн ажилласан байна.	Т, Г




	олгох ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;		
	4.Хөрөнгө оруулалт эрэлхийлсэн дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хөдөө аж ахуй, аялал жуулчлал болон бусад салбарын тэргүүлэх төслүүдэд хөрөнгө оруулалт татах, төслийн мэдээллийн сан үүсгэх, цахим хуудсаар сурталчлах;	Төслийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэсэн байна.	Т, Г
	5.Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчны талаарх мэдээллийг гадаадын хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдэд танилцуулж, сурталчлах зорилгоор бизнес, хөрөнгө оруулалтын форум зэрэг арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах;	Хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Г
	6.Олон улсын форум, уулзалт, үзэсгэлэн зэрэг арга хэмжээг зохион байгуулагч талуудтай мэдээлэл солилцох, хамтран ажиллах;	Төрийн үйлчилгээг шуурхай үзүүлж ажилласан байна.	Г
	7.Олон улсын форум, уулзалт, үзэсгэлэн зэрэг арга хэмжээнд оролцох, дотоодын үйлдвэрлэгчид, экспортлогчдыг оролцуулах бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах;	Холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Г
	8.Хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдэд зохиулсан гарын авлага, төслийн танилцуулга, хөтөч ном зэргийн эхийг бэлтгэж, хэвлүүлэх.	Гарын авлага, төслийн танилцуулга номын эхийг бэлдэж, хэвлүүлсэн байна.	Т, Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Нэгжийн үйл ажиллагааны зорилтыг хангахад чиглэсэн өөрийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, биелэлтийг ханган ажиллаж, тайлагнах;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө нь хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	2.Нэгжийн чиг үүрэгтэй холбоотой мэдээ, тайлан, судалгаа гаргаж танилцуулах;	Мэдээ, тайлан, судалгаа үнэн зөв, хугацаандаа гарсан байна.	Г



	3.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж, үр дүнг мэдээлэх;	Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж, тайлагнасан байна.	Г
	4.Төрийн албаны тухай хууль болон төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын дотоод журам, бусад төрийн албаны стандартыг мөрдөж хэрэгжүүлэх;	Төрийн албаны тухай хууль болон бусад стандарт дүрэм, журмын зөрчилгүй байна.	Г
	5.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон Авлигын эсрэг хууль тогоомжийг мөрдөх, хэрэгжилтийг хангах;	Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Г
	6.Хөрөнгө оруулалтыг дэмжих хэлтсийн мэргэжилтний эзгүйд түүний албан үүргийг түр орлон гүйцэтгэж, өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж ажиллах;	Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн, тасралтгүй явагдана.	Г
	7.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	Үүргээ зохих ёсоор хэрэгжүүлсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> - Эдийн засаг (0311); - эрх зүй (042101, 042103); - бизнес ба удирдахуй (041101, 041201-041203, 041301-041303); - гадаад хэлний орчуулга (023101). 	
Мэргэшил		
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй; - мэдээлэлд тулгуурлан дүгнэлт шинжилгээ хийх; - судалгааны үр дүн, шийдлийн хувилбаруудын шууд ба шууд бус үр дагаврыг харьцуулан үнэлэх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх;



		<ul style="list-style-type: none"> - хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд санал, зөвлөмж өгөх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Өөрийн чиг үүргийн хүрээнд хуульд нийцсэн, үр дүнтэй шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах; - удирдлагыг цаг үеийн шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангаж, зөв шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлэх; - тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарын эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах.
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> - Ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, цагийг баримтлан, харилцааны соёлтой байх, ажил хэрэгч байдлаар үлгэрлэх; - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; - нэгжийн үйл ажиллагаанд шинэлэг санаа, үйлчилгээг нэвтрүүлэх, албан хаагчдын шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг дэмжих; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд нэгжийн хамт олныг үлгэрлэх; - хамт олны саналыг сонсох, тусгах, өөрчлөлтийг хийхдээ урьдчилан тооцоолж, манлайлан удирдах.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - Англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх; - Хятад, Орос, Солонгос, Япон хэлний мэдлэгтэй бол давуу тал болно; - өөрийн гүйцэтгэлдээ хариуцлага хүлээдэг байх; - өөрийгөө хөгжүүлэх боломжийг эрэлхийлдэг байх; - мэдээ, мэдээллийг ойлгомжтой, товч, тодорхой, логиктой танилцуулдаг байх; - баримт бичиг, тайлан, мэдээ мэдээллийг үнэн зөв, товч тодорхой, шаардлагад нийцүүлэн боловсруулах чадвартай байх; - монгол улсын хууль тогтоомжийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдах; - төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэх, ёс зүйн холбогдолтой хууль, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөх, манлайлах; - авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.

V. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Хөрөнгө оруулалтыг дэмжих хэлтсийн дарга



<p><u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u></p>	<p><u>Бусад харилцах субъект</u></p> <ul style="list-style-type: none"> - Төрийн болон орон нутгийн байгууллагын холбогдох албан тушаалтан; - Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан; - Гадаад улс орнуудын төрийн болон төрийн бус байгууллага, тэдгээрийн холбогдох албан тушаалтан, гадаадын иргэн, хуулийн этгээд; - Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага, бусад хуулийн этгээд.
<p>V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ</p>	
<p><u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u></p>	<p><u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u></p>
<p><u>Албан тушаал:</u></p> <p>ЗАХИРГАА, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ХҮНИЙ <u>НӨӨЦИЙН</u> МЭРГЭЖИЛТЭН (<u>Н. Энхбаатар</u>)</p> <p>2023 оны <u>11</u> дүгээр сарын <u>30</u> -ны өдөр</p>	<p>Байгууллагын нэр: ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ</p> <p>Шийдвэрийн огноо: 23 11 23</p> <p>Дугаар: 496</p>
<p>Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:</p>	
<p><u>Байгууллагын нэр:</u></p> <p>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДААНЫ ГАЗАР</p> <p><u>Шийдвэрийн огноо:</u> <u>2023. 11. 30</u></p> <p><u>Дугаар:</u> <u>A/16</u></p> <p>(тамга/ тэмдэг)</p> <p>ДАРГА <u>В. Энхбаатар</u> (В.ЭНХБААТАР)</p> <p>2023 оны <u>11</u> дүгээр сарын <u>30</u> -ны өдөр</p>	

